



ХӨВСГӨЛ АЙМАГ  
ЦАГААН-УУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 45

Шарга

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
хуралдаан зарлах, хэлэлцэх асуудал  
товлох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит VIII хуралдааныг 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 10 цагт Иргэний танхимд хуралдуулсугай.
2. Тус хуралдаанаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.
  1. Тэс голын эхийг улсын тусгай хамгаалалтанд авах тухай/Их, бага элээт, Гандан нуурын ай сав/.
  2. 2014 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл, 2015 онд хийгдэх ажлын эрэмбийг танилцуулах.
  3. Газрын төлбөр, татварын үнэлгээний бүсийг тогтоох тухай.
  4. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай.
3. Хуралдааны бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
4. Хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдааны зар хүргэх ажлыг зохион байгуулахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа /, Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч /Т.Мөнхбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Ч.АЗБАЯР



0011